



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 0/1862

Мандалговь

Архи, согтууруулах ундаа худалдах,  
түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай  
зөвшөөрлийн эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2.2.1, 5.3 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалт, 8.1 дүгээр зүйлийн 12.13 дахь хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хавсралтад дурдсан аж ахуйн нэгжийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 2029 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хүртэл хугацаагаар олгосугай.

2.Холбогдох хууль, журмын дагуу аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавихыг Засаг даргын орлогч (Ц.Ариунбаяр)-д, тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.МӨНХЧУЛУУН

4824101703

Дундговь аймгийн Засаг даргын 2024 оны  
1.2 дугаар сарын 02-ны өдрийн А/362 дугаар  
захирамжийн хавсралт



### АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Аж ахуйн нэгжийн хаяг
1	2	3	4	5
1	Сайнцагаан	Гандөл хангай	худалдаа	5-р баг А1-107 А
2	Сайнцагаан	Номин бизнес клуб зүүн бүс	худалдаа	7-р баг Нарлаг их тойруу-8
3	Сайнцагаан	Эгшиглэнт бүрд	худалдаа	9-р баг Мандал 16-2
4	Сайнцагаан	Хишиг цагаан овоо	худалдаа	7-р баг Нарлаг 155-12
5	Сайнцагаан	Премиум нэксус	худалдаа	6-р баг Боржигон 7-1Б
6	Гурвансайхан	Буман цагаан хоньт	худалдаа	7-р баг Нарлаг 146
7	Өндөршил	Мөнхдүүрэн арвай	худалдаа	1-р баг Цог зоог 1-1
8	Өндөршил	Мөртийн булаг	үйлчилгээ	3-р баг Бөхт 6-604